



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны “Аян зохион байгуулах тухай” А/319 дүгээр тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам”-ын 2.2.6 дахь хэсэг, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны “Тэтгэвэр тогтоолт, олголтод хийсэн шалгалтын аяны мөрөөр авах арга хэмжээний тухай” А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн итгэмжлэлээр тэтгэвэр авагчийн итгэмжлэлийн үндэслэл, хугацаа, тэтгэврийн олголт, тэтгэврийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний болон улсын төсвийн сангийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, тэтгэврийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр олгох журам”-ыг нэгдүгээр, “Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авах хүсэлт”-ийн загварыг хоёрдугаар, “Тэтгэвэр олгох зөвшөөрлийн хуудас”-ны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмыг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нарт, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулж 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн дотор хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), харилцагч банкуудыг мэдээллээр хангаж ажиллахыг Санхүү, бүртгэлийн газар (Б.Даваахүү), “Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр олгох журам”-ын хэрэгжилтийн явц, үр дүнг улирал бүр Газрын даргын зөвлөлд танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Хяналт, шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.



ДАРГА

Д.ЗОРИГТ

1000717



Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн А/С дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Өөрийн биеэр тэтгэврээ авах боломжгүй тэтгэврээ авагчийн “Зөвшөөрлийн хуудас”-аар ТЭТГЭВЭР авах тухай _____ аймаг (сум), дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч)-т хүсэлт гаргах нь:

Дугаар

.....аймаг, дүүргийн.....дүгээр баг, хорооны иргэнтоот тэтгэврийн дэвтрээр өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны (аль төрөл болохыг доогуур нь зурах) тэтгэврээ авагч.....овогтойминий бие өндөр настай, хэвтрийн хүнд өвчтэй, гадаад улсад оршин суух (аль төрөл болохыг доогуур нь зурах) шалтгааны улмаас өөрийн биеэр сар бүр тэтгэврээ авах боломжгүй байгаа тул.....овогтой-ийг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр.....сарын хугацаатай итгэмжилж байна.

Иймдовогтой-д тэтгэврээ олгох зөвшөөрөл олгохыг хүсье.

Хүсэлт гаргасан:

Хүсэлт хүлээн авсан:

Нийгмийн даатгалын байцаагч

_____/_____/ (гарын үсэг) (нэр)

_____/_____/ (гарын үсэг) (нэр)

Оршин суугаа хаяг:

Харилцах утасны дугаар:

Тайлбар: Гадаадад оршин суугч бол тухайн улсад оршин сууж байгаа хаягаа бичнэ.

201 . . . оны . . . сар . . . өдөр

201 . . . оны . . . сар . . . өдөр



Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/154 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ТЭТГЭВЭР ОЛГОХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

20.....он.....сар.....өдөр

Дугаар

.....банкны харъяатооцооны төвд:

Тэтгэвэр авагчийн овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Дэвтрийн дугаар: _____
Тэтгэврийн төрөл: _____
Зөвшөөрлөөр тэтгэвэр авах
Итгэмжлэгдсэн хүний овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Зөвшөөрлөөр тэтгэвэр олгох
шалтгаан: _____
Эхлэх хугацаа: _____
Дуусах хугацаа: _____

Тэтгэвэр олгох зөвшөөрлийн хуудас бичсэн:

.....аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Тэтгэврийн байцаагч /нэр, гарын үсэг, тэмдэг/

Тэтгэвэр олгох зөвшөөрлийн хуудсыг баталгаажуулсан:

.....аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Нийгмийн даатгалын Үйлчилгээний тасгийн дарга / нэр, гарын үсэг, тэмдэг/



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДСААР ТЭТГЭВЭР
ОЛГОХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-НДБХСГ- 05- 2017

Баталсан: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын
ерөнхий газрын дарга Д.Зоригт

Хянасан: Нийгмийн даатгалын бодлогын
хэрэгжилт, судалгааны газрын
дарга Ц.Ганцэцэг

Боловсруулсан: Нийгмийн даатгалын бодлогын
хэрэгжилт, судалгааны газрын
мэргэжилтэн *Дардас* М.Бямбадулам

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	



Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
ЭМНДЕГ-ын НДБХСГ	A/.....	2017-10-10	2017-10-16	9

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1			
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			



АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Үндсэн хэсэг
6. Хариуцлага



Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/154 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДСААР ТЭТГЭВЭР ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан нөхцөл, болзлын дагуу өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг итгэмжлэгдсэн хүнд нь итгэмжлэлийн хугацаанд олгох, тэтгэврээ итгэмжлэлээр авч байгаа иргэдийн тэтгэврийн олголттой холбоотой зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, итгэмжлэлийн хугацаа, тэтгэврийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан, улсын төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, тэтгэврийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй үзүүлэхэд энэ журмын зорилго оршино.

1.2.Энэ журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан нас хөгширсөн, өвчилсөн зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас болон тэтгэвэр тогтоолгосны дараа гадаад улсад удаан хугацаагаар, байнга оршин суухаар шилжин явсны улмаас өөрийн биеэр ирж тэтгэврээ сар бүр авах боломжгүй Монгол Улсын иргэдийн хууль ёсны итгэмжлэгдсэн хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч (цаашид “Зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэн” гэх)-д тэтгэврийг нь тэтгэвэр олгох зөвшөөрлийн хуудас (цаашид “зөвшөөрлийн хуудас” гэх)-аар олгох харилцааг зохицуулна.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1.Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.5 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны “Аян зохион байгуулах тухай” А/319 дүгээр тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам”-ын 2.2.6 дахь хэсэг, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны “Тэтгэвэр тогтоолт, олголтод хийсэн шалгалтын аяны мөрөөр авах арга хэмжээний тухай” А/133 дугаар тушаал зэргийг тус тус үндэслэн энэхүү журмыг боловсруулав.

ГУРАВ. Хамаарах талууд

3.1.Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нас хөгширсөн, өвчилсөн зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас болон тэтгэвэр тогтоолгосны дараа



гадаад улсад удаан хугацаагаар болон байнга оршин суухаар шилжин явсны улмаас өөрийн биеэр ирж тэтгэврээ сар бүр авах боломжгүй иргэд (цаашид “Өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэн” гэх), зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэн, аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (цаашид “Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага” гэх), тэтгэвэр олгодог харилцагч банк (цаашид “банк” гэх)-ууд.

3.2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийг зөвшөөрлийн хуудсаар олгохдоо энэхүү журмыг мөрдөнө.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Үндсэн хэсэг

А. Зөвшөөрлийн хуудас олгох

5.1. Өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэдийн тэтгэврийг зөвшөөрлийн хуудсаар дор дурдсанаар олгоно. Үүнд:


5.1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан тэтгэвэр авагчийн тэтгэврийг зөвшөөрлийн хуудсаар олгоно.

5.1.2. Өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийг Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т заасан шаардлагыг хангасан итгэмжлэл бүхий иргэнд олгоно.

5.1.3. Зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэн нь оршин суугаа баг, хорооны болон тэтгэвэр авагчийн эрүүл мэндийн талаарх эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, тэтгэврийн дэвтэр, нотариатын итгэмжлэл, өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэн болон зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авах иргэний иргэний үнэмлэхийн хамт тэтгэвэр авагчийн харьяаллын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргана.

5.2. Гадаад улсад оршин сууж, амьдарч байгаа өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийг зөвшөөрлийн хуудсаар дор дурдсанаар олгоно. Үүнд:

5.2.1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгосны дараа гадаад улсад удаан хугацаагаар (6 сар ба түүнээс дээш) болон байнга оршин суухаар шилжин явсны улмаас өөрийн биеэр ирж тэтгэврээ сар бүр авах боломжгүй тэтгэвэр авагч (цаашид “гадаад улсад амьдарч байгаа тэтгэвэр авагч” гэх)-ийн тэтгэврийг энэ журмын 5.1.2-т зааснаар итгэмжлэл олгогдсон хүнд зөвшөөрлийн хуудсаар олгоно.





5.2.2. Гадаад улсад амьдарч байгаа тэтгэвэр авагч нь тухайн оршин суугаа улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт хаягийн бүртгэл хийлгэсэн, тухайн улсад оршин сууж байгаа тухай, хэрэв Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар байхгүй тохиолдолд тухайн улсын Засаг захиргааны байгууллагаас тус улсад оршин сууж байгаа тухай тодорхойлолтыг жил бүр гаргуулан авч дараа оны 1 дүгээр сард багтаан тэтгэвэр авагчийн харьяа эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад албан ёсоор ирүүлнэ.

5.2.3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэнд энэ журмын 5.2.2-т заасан баримт бичиг болон бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн зөвшөөрлийн хуудас олгож гадаад улсад амьдарч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг итгэмжлэлийн хугацаанд олгоно.

5.2.4. Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авч байгаа гадаад улсад амьдарч байгаа тэтгэвэр авагчийн энэ журмын 5.2.2, 5.2.3-т заасан баримт бичгийг тэтгэврийн хувийн хэрэгт нь хадгална.

5.2.5. Гадаад улсад амьдарч байгаа тэтгэвэр авагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 1 жил ба түүнээс дээш хугацаанд энэ журмын 5.2.2-т заасан тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд өөрийн биеэр ирж тэтгэврээ авах хүсэлт гаргах хүртэл хугацаанд тэтгэврийг нь түр түдгэлзүүлэн зогсооно.

Б.Зөвшөөрлийн хуудсыг баталгаажуулах

5.3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь дараах шаардлагыг хангасан зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэнд энэ журмын 5.1.1, 5.2.1-т заасан тэтгэвэр авагчийн тэтгэврийг олгоно. Үүнд:

5.3.1. Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авах иргэн нь энэ журмын 5.1.3, 5.2.2-т заасан баримт бичгийг бүрдүүлэн хүсэлтийн хамт тэтгэвэр авагчийн харьяа Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргасан;

5.3.2. Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авах иргэний нотариатын итгэмжлэл нь энэ журмын 5.1.2-т заасан шаардлагыг хангасан байх зэрэг болно.

5.4. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэнд энэ журмын 5.3.1-д заасан баримт бичиг, тэтгэврийн дэвтрийг үндэслэн зөвшөөрлийн хуудас олгож дор дурдсанаар баталгаажуулна. Үүнд:

5.4.1. Аймаг, дүүрэгт зөвшөөрлийн хуудсыг тэтгэврийн байцаагч бичиж, бүртгэл хөтлөн Нийгмийн даатгалын үйлчилгээний тасгийн дарга хянаж, баталгаажуулна.

5.4.2. Тасаг бүхий суманд зөвшөөрлийн хуудсыг тэтгэврийн байцаагч, тэтгэврийн байцаагчгүй тохиолдолд сумын байцаагч бичиж, бүртгэл хөтлөн сумын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын тасгийн дарга хянаж, баталгаажуулна.





5.4.3. Суманд сумын байцаагч аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Нийгмийн даатгалын үйлчилгээний тасгийн даргад мэдэгдэж зөвшөөрөл авч бүртгэл хөтөлсний үндсэн дээр зөвшөөрлийн хуудас бичиж гарын үсэг зурж баталгаажуулна.

В. Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр олгох

5.5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийг зөвшөөрлийн хуудсаар дор дурдсанаар олгоно. Үүнд:

5.5.1. Энэ журмын 5.1.3, 5.2.2-т заасан баримт бичгийг үндэслэн зөвшөөрлийн хуудсыг 6 сарын хугацаагаар олгож, зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авч байгаа иргэдийн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж холбогдох баримт бичгийг сар, улирлаар нэгтгэн архивын нэгж болгон хэлтсийн архивт хадгална.

5.5.2. Өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй болон зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэд зөвшөөрлийн хуудасны хугацааг энэ журмын 5.5.1-д заасан хугацаанаас өмнө цуцлах хүсэлт гаргасан тохиолдолд зөвшөөрлийн хугацааг цуцална. Энэхүү хүсэлтийг тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт хадгална.

5.5.2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 5.1.3, 5.2.2-т заасан баримт бичиг, тодорхойлолтыг хугацаанд нь ирүүлсэн зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэнд тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгох асуудлыг шийдвэрлэнэ.

5.5.3. Гадаад улсад амьдарч байгаа өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийг энэ журмын 5.2.2-т заасан тодорхойлолтыг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд тэтгэвэр авагчийн тодорхойлолтоо ирүүлэх хүртэл хугацаанд тэтгэврийг нь түр түдгэлзүүлэн зогсооно.

5.5.4. Гадаад улсад амьдарч байгаа тахир дутуугийн тэтгэвэр авагч Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хуралд өөрийн биеэр оролцож, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь, хугацаагаа тогтоолгосон байна.

5.5.5. Өөрийн биеэр тэтгэврээ ирж авах боломжгүй иргэний тэтгэвэр авах эрх Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нөхцөлөөр дуусгавар болно.

5.5.6. Гадаад улсад амьдарч байгаа өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэн нас барсан тохиолдолд зөвшөөрлөөр тэтгэвэр авагч нь энэ тухай Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэ журмын 5.2.2-т заасан тодорхойлолтыг үндэслэн түүний ар гэрт нь нас барсны дараагийн сарын тэтгэвэр болон оршуулгын тэтгэмжийг нь холбогдох сангуудаас тооцож олгоно.

5.5.7. Зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэн зөвшөөрлийн хуудасны хугацааг сунгуулах тохиолдол бүрт энэхүү журмын 5.1.3-т заасан баримт бичгийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.





5.5.8. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь зөвшөөрлийн хуудасны хугацаа дуусмагц зөвшөөрлийн хуудсыг өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийн хувийн хэрэгт хадгална.

Г. Тэтгэврийн олголтод тавих хяналт

5.6. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийн олголтыг дараах чиглэлээр хянаж шалгана. Үүнд:

5.6.1. Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчийн итгэмжлэлийн үндэслэл, хугацааны сунгалтыг улирал бүр хянаж баталгаажуулна.

5.6.2. Өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэнд зөвшөөрлийн хуудсаар олгосон тэтгэврээ тухай бүр авч байгаа эсэхийг уг тэтгэвэр авагчтай гэрээр нь очиж уулзах замаар хяналт тавина.

5.6.3. Өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэвэр авах эрх дуусгавар болж байгаа эсэхийг сар бүр хянаж ажиллана.

5.6.4. Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авч байгаа иргэдийн мэдээллийг тэтгэврийн мэдээллийн санд тухай бүр оруулж, холбогдох судалгаа, итгэмжлэлийн үндэслэл болон тэтгэврийн олголтыг шалгасан дүн, мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шалгалтын газарт ирүүлнэ.

5.7. Банк өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэнд тэтгэврийг нь олгохдоо дараах чиглэлийг баримталж ажиллана. Үүнд:


5.7.1. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын олгосон зөвшөөрлийн хуудас, өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй тэтгэвэр авагчийн иргэний үнэмлэх, тэтгэврийн дэвтэр, зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авагчийн иргэний үнэмлэхийг тус тус үндэслэн тэтгэвэр олгох бөгөөд зөвшөөрлийн хуудасны хуулбарыг авч баримтандаа хадгална.

5.7.2. Банк нь зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авч байгаа иргэний тэтгэврийн олголтын тооцоог Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай сар бүр хийнэ.

5.7.3. Зөвшөөрлийн хуудсаар тэтгэвэр авч байгаа иргэнд тэтгэврийн зээл олгохгүй.

ЗУРГАА. Хариуцлага

6.1. Зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэн нь өөрийн биеэр ирж тэтгэврээ авах боломжгүй иргэний итгэмжлэгдсэн хүн солигдох тохиолдолд энэ журмын 5.1.3, 5.2.2-т заасан баримт бичгийг бүрдүүлэн тэтгэвэр авагчийн харьяа эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргана.






6.2. Өөрийн биеэр тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийн эрх дуусгавар болох тохиолдолд зөвшөөрлөөр тэтгэвэр авах иргэн энэ тухай Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

6.3. Өөрийн биеэр тэтгэврээ авах боломжгүй иргэний тэтгэврийн эрх дуусгавар болсноос хойш зөвшөөрлөөр тэтгэвэр авч байгаа иргэн тэтгэврийг хууль бусаар илүү авсан тохиолдолд хохирлыг тэтгэврийн даатгалын санд төлж барагдуулах үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд уг асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

6.4. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд үүсэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай албан тушаалтанд хүлээлгэнэ.



---oOo---